



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2022

## NEWFUND

Email: [info@newfund.mn]

Website: [www.newfund.mn]

Tel: [75775599] УБ, СБ, 1-р хороо,

ЮНЕСКО-ийн гудамж - 28, МПМ 7



# АГУУЛГА

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА _____	3
КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА _____	4
НЬЮФОНД ББСБ ХХК ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ _____	5
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН _____	6
ХАМТ ОЛОН _____	8
Дотоод аудитын тогтолцоо _____	9
Бүтээгдэхүүн, үйлчилгээ _____	10
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН _____	11
САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД _____	12
ТУЗ-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан _____	14
ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан _____	18

## КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Ньюфонд Банк Бус Санхүүгийн Байгууллага нь 2004 онд Ньюком ХХК болон Мобиком Корпораци ХХК-ийн хамтарсан хөрөнгө оруулалттайгаар групп компаниудын ажилтнуудад орон сууцны урт хугацаат хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор байгуулагдсан Мобиком Корпораци ХХК-ийн анхны охин компани юм.



Ньюфонд ББСБ нь 2008-2012 онд Монгол улсын засгийн газар, Худалдаа аж үйлдвэрийн танхимаас хамтран шалгаруулдаг TOP-10 ББСБ-ын нэгээр шалгарсан бөгөөд 2010 онд ББСБ-ын Холбооны "Оны шилдэг Хөрөнгө орлуулагч ББСБ" -аар мөн шалгарч байсан юм.

# КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** Бид өөрсдийн сонгосон зах зээлд тэргүүлэгч ББСБ болж, санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлж, нийгэмд маш сайн үр өгөөжөө өгөхийг эрмэлздэг.

**АЛСЫН ХАРАА:** Группийн компаний ажилтнуудын санхүүгийн хэрэгцээг хангах, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад чиглэсэн санхүүгийн үйлчилгээг тогтмол үзүүлэх явдал юм.

**УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО:** Группын компаний ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх банк санхүүгийн байгууллага болох явдал юм.



# НЬЮФОНД ББСБ ХХК ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ





# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

## ТУЗ-н дарга



Ф. ЯСУХИКО

### ТУРШЛАГА

- 1996-2019 KDDI группд Охин компаниудын менежмент
- 1996-2019 KDDI Группд Төсвийн төлөвлөлт, хяналт хариуцсан ажилтан
- 1996-2019 KDDI Группд Санхүүгийн менежер
- 2019 оноос хойш Мобиком Корпораци ХХК, Санхүү Хариуцсан Тэргүүн Дэд Захирал

## ТУЗ-н ердийн гишүүд



Б. ҮНЭНБАТ

### ТУРШЛАГА

- 2004-2014 Ньюком ХХК, Гүйцэтгэх захирал, Санхүүгийн асуудал эрхэлсэн захирал
- 2014-2015 Шунхлай групп ХХК, Санхүүгийн асуудал эрхэлсэн захирал
- 2015-2017 Сийд лимитд ХХК, Гүйцэтгэх захирал
- 2017 оноос хойш Мобиком Корпораци ХХК, Санхүүгийн Асуудал Эрхэлсэн Дэд Захирал
- 2017-2022 Ньюфонд ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал
- 2021-2022 Мобифинанс ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал



Э. ЭРДЭНЭСҮРЭН

### ТУРШЛАГА

- 2017-2018 ХЗДХЯ, Газрын дарга
- 2018-2019 ХЗДХЯ-Оюуны өмчийн газар, Агентлагийн дарга
- 2019 оноос хойш Мобиком Корпораци ХХК, Хууль эрх зүй, Бодлого зохицуулалт Эрхэлсэн Дэд Захирал



**Ш. ЭРДЭНЭБАЯР**

**ТУРШЛАГА**

2013-2016

Прайсуотерхаус Куперс Аудит  
ХХК, Зөвлөх

2013-2016

Прайсуотерхаус Куперс Аудит  
ХХК, Ахлах зөвлөх

2016 оноос хойш

Ньюком ХХК, Шинжээч, Ахлах  
шинжээч, Менежер, Санхүү  
эрхэлсэн захирал

**ТУЗ-н хараат бус гишүүн**

**ТУРШЛАГА**



**З. ОЮУНЦАЦРАЛ**

1996-2022

СЭЗИС, Багш

2007-2009

ARDP, Санхүүгийн зөвлөх

2012-2015

СЭЗИС, Хэлтэсийн дарга

2019 оноос хойш

ДоБиЧи Консалтинг ХХК, Гүйцэтгэх  
захирал

2022 оноос хойш

Эрдэнэс Таван Толгой ХХК, Зөвлөх

2022 оноос хойш

СЭЗИС, Профессор

**ТУЗ-н нарийн бичгийн дарга**

**ТУРШЛАГА**



**Б. БЯМБАЖАРГАЛ**

2011-2013

Ньюфонд ББСБ, Нягтлан бодогч

2013-2022

Ньюфонд ББСБ, Ерөнхий нягтлан  
бодогч

2022 оноос хойш

Ньюфонд ББСБ, Менежер

## ХАМТ ОЛОН



Б.Соёлчимэг нь 2005 оноос Мобиком Корпорацид ажлын гараагаа Борлуулалт үйлчилгээний ажилтнаар эхлүүлж, Хүний нөөцийн албаны мэргэжилтэн, Ахлах мэргэжилтэн, Менежер, Ахлах менежерээр ажиллаж, 2020 оны 4 дүгээр сараас эхлэн Хүний нөөцийн газрын захирлаар томилогдон ажиллаж байна.

Мөн Мобиком Группийн охин компани болох Ньюфонд ББСБ, Ньютел ХХК-ын шууд удирдлагын үүргийг гүйцэтгэж байна.

Ньюфонд ББСБ нь Ньюком болон Мобиком групп компаниудын ажилтнуудын эрэлт хэрэгцээ, хүсэл зорилгод нийцсэн санхүүгийн тогтвортой үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор группын 2000 –аад ажилтнууд, тэдний гэр бүлийнхний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төрөл бүрийн зээлийн хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.





## Дотоод аудитын тогтолцоо

Ньюфонд ББСБ ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны хамгаалалтын буюу эрсдэлийг удирдах 3 үе шат бүхий дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажилладаг. Эдгээр нь дотоод хяналт, комплайнс болон дотоод аудит болно.

Хамгаалалтын гуравдугаар үе шат буюу компанийн Дотоод аудит нь байгууллагад үүссэн алдаа зөрчлийг олж илрүүлэн тайлагнахаас гадна хууль тогтоомжийг мөрдөж буй эсэх, компанийн засаглал ба гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг, эрх мэдэл, үүрэг хариуцлага, тулгарч буй, эсхүл болзошгүй эрсдэлийг зохистой удирдаж байгаа эсэх, дотоод хяналтын тогтолцоог оновчтой бүрдүүлсэн эсэхийг тодорхойлж, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, зөвлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийг шалгуур:**

Бизнес төлөвлөгөөнд тусгасан зорилтуудын биелэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин болон бусад урамшууллыг олгодог. Үүнд доорх үндсэн бүлэг үзүүлэлтүүдийг багтаана.

- Санхүүгийн зорилтуудын биелэлт
- Бизнесийн зорилтууд: Стратеги, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчийн үйлчилгээний зорилтуудын биелэлт
- Дотоод процессын сайжруулалт, комплайнс, засаглал, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны зорилтуудын биелэлт
- Хүний нөөцийн хөгжил, чадавхижуулалттай холбоотой зорилтуудын биелэлт;

## Бүтээгдэхүүн, үйлчилгээ



### Цалингийн зээл:

Групп компанийн ажилтнуудын санхүүгийн хэрэгцээнд зориулан хөнгөлөлтэй нөхцлөөр олгодог зээлийн үйлчилгээ юм.



### Орон сууцны зээл:

Групп компаниудын ажилтнуудад орон сууц, хашаа байшин авахад зориулан хөнгөлөлтэй нөхцлөөр олгодог зээлийн үйлчилгээ юм.



### Итгэлцлийн үйлчилгээ:

Итгэлцлийн гэрээний үндсэн дээр тодорхой хугацаа болон хүүтэйгээр шилжүүлсэн харилцагчийн мөнгөн хөрөнгийг ББСБ нь харилцагчийн өмнөөс эрсдэлийг тооцож, найдвартай байдлыг харгалзан зээл болон бусад төрлийн хөрөнгө оруулалтад байршуулж, өсгөх үйлчилгээ юм.

# 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Ньюфонд ББСБ нь 2022 оны 12-р сарын 31-ны байдлаар Мобиком корпораци, Ньютел ХХК, Ньюком ХХК, Монгол Контент ХХК, Мобинет ХХК болон Ньюком Проперти ХХК гэсэн 6 хувь нийлүүлэгчийн 4,7 тэрбум төгрөгийн дүрмийн сантай 7.5 тэрбум төгрөгийн активтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны 4 сараас менежер, 2022 оны 6 сараас гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн шинэ бүтэц, хамт олонтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

## Бизнесийн үйл ажиллагаа

### 1

#### Харилцагчийн тоо:

Өмнөх оноос 1.2 дахин өссөн



### 2

#### Зээлийн багц:

Өмнөх оноос 1.3 дахин өссөн

### 3

#### Зээлийн олголт:

Өмнөх оноос 1.2 дахин өссөн



# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Ernst & Young Mongolia Audit LLC  
Suite 200, 8 Zovkhis Building  
Seoul Street 21  
Ulaanbaatar 14251  
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005  
Fax : +976 11 312042  
ey.com

## САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Ньюфонд ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

#### Дүгнэлт

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг Ньюфонд ББСБ ХХК ("Компани")-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

#### Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

#### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн.

#### Санхүүгийн хураангуй тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Компанийн удирдлагын хариуцлага юм.

#### Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АУОС") 810 буюу "Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

  
Ernst & Young Mongolia Audit LLC  
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК  
Мэргэшсэн Нягтлан Бодогчид

  
Доржбатын Мандахбаяр  
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс  
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 17



**НЬЮФОНД ББСБ ХХК**  
**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	2022 мян.төг	2021 мян.төг
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	793,182	656,938
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн зардал	<u>(18,963)</u>	<u>(19,685)</u>
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b><u>774,219</u></b>	<b><u>637,253</u></b>
Хүлээгдэж буй зээлийн алдагдлын зардал	<u>(3,625)</u>	<u>(2,426)</u>
<b>Зээлийн алдагдлын дараах цэвэр хүүгийн орлого</b>	<b><u>770,594</u></b>	<b><u>634,827</u></b>
Бусад үйл ажиллагааны орлого	453,332	272,194
Удирдлага болон бусад үйл ажиллагааны зардал	<u>(453,261)</u>	<u>(405,956)</u>
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b><u>770,665</u></b>	<b><u>501,065</u></b>
Орлогын албан татварын зардал	<u>(8,680)</u>	<u>(12,872)</u>
<b>Тайлан жилийн цэвэр ашиг буюу нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b><u>761,985</u></b>	<b><u>488,193</u></b>



**Б. Үнзибат**  
 Санхүүгийн Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс  
 Огноо: 2023 оны 3 дугаар сарын 17

*Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь санхүүгийн байдлын тайлан, ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

**НЬЮФОНД ББСБ ХХК**  
**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**  
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	2022 MNT'000	2021 MNT'000
<b>Хөрөнгө</b>		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	595,311	1,456,598
Хэрэглэгчдэд олгосон зээл ба урьдчилгаа	6,595,866	5,047,265
Бусад хөрөнгө	99,003	48,379
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,098	3,120
Үндсэн хөрөнгө	37,168	10,281
Ашиглах эрхтэй хөрөнгө	132,709	105,258
<b>Нийт хөрөнгө</b>	<u>7,462,155</u>	<u>6,670,901</u>
<b>Өр төлбөр</b>		
Бусад өр төлбөр	32,775	37,025
Түрээсийн өр төлбөр	134,903	121,911
Орлогын албан татварын өр төлбөр	21,561	1,034
<b>Нийт өр төлбөр</b>	<u>189,239</u>	<u>159,970</u>
<b>Эздийн өмч</b>		
Хувьцаат капитал	4,729,521	4,729,521
Хуримтлагдсан ашиг	2,543,395	1,781,410
<b>Нийт эздийн өмч</b>	<u>7,272,916</u>	<u>6,510,931</u>
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<u>7,462,155</u>	<u>6,670,901</u>

**Нийт өр төлбөр болон эздийн өмч**

**Б. Соёлчимэг**  
 Гүйцэтгэх Захирал



**Б. Үнэнбат**  
 Санхүүгийн Захирал



Улаанбаатар хот, Монгол Улс  
 Огноо: 2023 оны 3 дугаар сарын 17

*Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь санхүүгийн байдлын тайлан, ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг оорчлолгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

# ТУЗ-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны

## ТАЙЛАН

ТУЗ-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан

2022 оны ТУЗ-ийн үйл ажиллагаа нь 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас батдагдсан “Компанийн тухай хууль” болон “Ньюфонд” ББСБ ХХК –ын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан “Компанийн дүрэм”-ийн хүрээнд ажиллаж, холбогдох шийдвэр тушаалуудыг гаргасан болно. 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан “Ньюфонд” ББСБ ХХК-ийн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, байгууллагын зорилго, зорилтыг зөв тодорхойлох, гүйцэтгэлийн арга замыг тогтоож, хэрэгжүүлэх бүтцийн дагуу чанд мөрдөж ажилласан болно.

**2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ТУЗ-н гишүүд:**

**Хүснэгт №1**

№	ТУЗ-н Гишүүн	Нэр	Албан тушаал
1	ТУЗ-н дарга	Фүкүй Ясүхико	Санхүү Хариуцсан Тэргүүн Дэд Захирал
2	ТУЗ-н гишүүн	Б.Үнэнбат	Санхүүгийн Асуудал Эрхэлсэн Дэд Захирал
3	ТУЗ-н гишүүн	Э.Эрдэнэсүрэн	Хууль эрх зүй, Бодлого зохицуулалт Эрхэлсэн Дэд Захирал
4	ТУЗ-н гишүүн	Х.Гүенбаатар	Санхүү эрхэлсэн захирал
5	ТУЗ-н хараат бус гишүүн	З.Оюунцацрал	Багш

**2022 онд ТУЗ-д хүрээнд орсон өөрчлөлтүүд:**

- 2022 онд нийт 7 ээлжит болон ээлжит бус ТУЗ-ийн хурлыг хуралдуулж, тогтоолуудыг гаргасан болно.
  - 2022 оны 05 сарын 30-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 01/22 дугаар шийдвэрээр Гүйцэтгэх захирал Б.Үнэнбатыг ажлаас чөлөөлж, Б.Соёлчимэгийг гүйцэтгэх захиралаар томилсон.
  - 2022 оны 05 сарын 30-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 02/22 дугаар шийдвэрээр ТУЗ-н нарийн бичгийн дарга Г.Алтангэрэлийг ажлаас чөлөөлж, Б.Бямбажаргалыг ТУЗ-н нарийн бичгийн даргаар томилсон.

## 2022 онд ТУЗ-ийн тогтоолын хураангуй жагсаалт

## Хүснэгт №2

№	Огноо	Тушаалын дугаар	Тушаалын агуулга	ТУЗ-ийн гишүүд
1	2022-05-30	АН ВоDM 01/22	ГЗ-г ажлаас чөлөөлж, ажилд томилох	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Б.Соёлчимэг Э.Эрдэнэсүрэн
2	2022-05-30	АН ВоDM 02/22	ТУЗ-н НБдарга ажлаа чөлөөлж, томилох	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Б.Соёлчимэг Э.Эрдэнэсүрэн
3	2022-10-05	АН ВоDM 03/22	"Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг батлах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
4	2022-10-05	АН ВоDM 04/22	ТУЗ-н дэргэдэх хороод байгуулах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
5	2022-10-05	АН ВоDM 05/22	ТУЗ-н дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам батлах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
6	2022-10-05	АН ВоDM 06/22	Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
7	2022-11-23	АН ВоDM 07/22	Зээлийн хүү бууруулах тухай -	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал

2. ТУЗ-ийн гишүүнийг ажлаас чөлөөлөх, томилохтой холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн 2 хурлыг дуудаж хуралдуулсан болно.

- 2022 оны 05 сарын 30-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 01/22 дугаар шийдвэрээр Д.Ариунаа, Ц.Ганзориг нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Б.Соёлчимэг, Э.Эрдэнэсүрэн нарыг тус тус ТУЗ-ийн гишүүнээр томилов.
- 2022 оны 10 сарын 05-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 02/22 дугаар шийдвэрээр Мобиком Корпораци ХХК-ийн төлөөлөл болох Б.Соёлчимэгийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, З.Оюунцацралыг ТУЗ-ийн хараат гишүүнээр томилов.



## 2022 онд ХЭХ-ын шийдвэрийн хураангуй жагсаалт

## Хүснэгт №3

№	Огноо	Тушаалын дугаар	Тушаалын агуулга	Хувьцаа эзэмшигчид
1	2022-05-30	АНШН 01/22	ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, томилох тухай	К.Курушима З.Гэрэлбадам Б.Мөнхзориг Б.Баатармөнх Д.Даваамаа Э.Чинзориг
2	2022-10-05	АНШН 02/22	ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, томилох тухай	К.Курушима З.Гэрэлбадам Б.Мөнхзориг Б.Баатармөнх Д.Даваамаа Э.Чинзориг

3. Санхүүгийн Зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23 өдрийн “Компанийн засаглалын кодекс” –ийг шинэчлэн батлах тухай тогтоолыг үндэслэн, 2022 оны 10 дугаар сарын 5-ний өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 03/22 тушаалын шийдвэрээр “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” батлагдсан.
- ТУЗ-н дэргэдэх хороодыг байгуулж, хороодын үйл ажиллагааны журмыг баталсан.
    - Аудитын дүрэм
    - Нэр дэвшүүлэх дүрэм
    - Цалин урамшууллын дүрэм
  - Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах жагсаалтыг баталсан
  - Уг ажлын хүрээнд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороог байгуулан, Аудитын хорооны даргаар Б.Үнэнбат, хорооны гишүүдээр Х.Гүенбаатар, Э.Эрдэнэсүрэн нарыг томилов.
  - ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороог байгуулан Цалин, урамшууллын хорооны даргаар З.Оюунцацралыг, хорооны гишүүдээр Ф. Ясүхико, Б. Үнэнбат нарыг томилов.
  - ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог байгуулан Нэр дэвшүүлэх хорооны даргаар З.Оюунцацралыг, хорооны гишүүдээр Ф. Ясүхико, Б.Үнэнбат нарыг томилов.

# ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан

2022 оны ТУЗ-ийн үйл ажиллагаа нь 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас батдагдсан “Компанийн тухай хууль” болон “Ньюфонд” ББСБ ХХК –ын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Компанийн дүрмэм” -ийн хүрээнд ажиллаж, холбогдох шийдвэр, тушаалуудыг гаргахад бэлтгэх, ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын баримт бичгүүдийг хариуцан ажилласан болно.

2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан “Ньюфонд” ББСБ ХХК-ийн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн арга замыг тогтоож, хэрэгжүүлэх бүтцийн дагуу чанд мөрдөж ажилласан болно.

## 2022 оны 12 сарын 31-ны байдлаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Хүснэгт №4

	Овог нэр	Хэлбэр	Албан тушаал
1	Б.Бямбажаргал	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Ньюфонд ББСБ-н менежер,

2022 онд ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь дараах ТУЗ-ийн тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүдийг гаргахад хурлын зар түгээх, хуралд бэлтгэж, холбогдох баримт бичгүүдийг хариуцаж ажилласан.

### 1. Хүснэгт №5

№	Огноо	Тушаалын дугаар	Тушаалын агуулга	ТУЗ-ийн гишүүд
1	2022-05-30	АН ВоDM 01/22	ГЗ-г ажлаас чөлөөлж, ажилд томилох	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Б.Соёлчимэг Э.Эрдэнэсүрэн
2	2022-05-30	АН ВоDM 02/22	ТУЗ-н НБдарга ажлаа чөлөөлж, томилох	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Б.Соёлчимэг Э.Эрдэнэсүрэн
3	2022-10-05	АН ВоDM 03/22	“Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батлах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал

4	2022-10-05	АН ВоDM 04/22	ТУЗ-н дэргэдэх хороод байгуулах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
5	2022-10-05	АН ВоDM 05/22	ТУЗ-н дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам батлах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
6	2022-10-05	АН ВоDM 06/22	Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал
7	2022-11-23	АН ВоDM 07/22	Зээлийн хүү бууруулах тухай -	Я.Фүкүй Х.Гүенбаатар Б.Үнэнбат Э.Эрдэнэсүрэн З.Оюунцарал

### 2022 онд ХЭХ-ын шийдвэрийн хураангуй жагсаалт

#### Хүснэгт №6

№	Огноо	Тушаалын дугаар	Тушаалын агуулга	Хувьцаа эзэмшигчид
1	2022-05-30	АНШН 01/22	ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, томилох тухай	К.Курушима З.Гэрэлбадам Б.Мөнхзориг Б.Баатармөнх Д.Даваамаа Э.Чинзориг
2	2022-10-05	АНШН 02/22	ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, томилох тухай	К.Курушима З.Гэрэлбадам Б.Мөнхзориг Б.Баатармөнх Д.Даваамаа Э.Чинзориг

Newfund NBFI LLC  
2022



Phone : +976-75775599

Address:

UNESCO Street-28, MPM Complex, Sukhbaatar  
district, Ist khoroo, Ulaanbaatar-14220, Mongolia

